

Гэмт хэргийн хохирогч болсон гадаад иргэдийн эрх болон туслах тогтолцооны талаарх мэдээлэл

Гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд мөрдөн байцаалт болон шүүхийн явцад дараах эрхийг эдлэх ба тусламж авах боломжтой

- Мөрдөн байцаалт болон шүүх хуралд айдас болон таагүй байдлаас болж итгэмжтэй хэн нэгэнтэй хамт очиж болох бөгөөд, илүү сайн ойлголцохын тулд орчуулагч дуудуулж болох ба, шүүх хуралд оролцож тухайн хэргийн талаар мэдэгдэл хийх боломжтой.
- Бэлгийн болон хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч нь эрүүгийн гэмт хэргийн мөрдөлтийн явцад хуулийн талын зөвлөгөө өгөх өмгөөлөгч авч болох ба өмгөөлөгч байхгүй бол Улсын прокурын газраас өгөх улсын үнэгүй өмгөөлөгчөөс тусламж авч болно.
- Гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллийн хохирогч нь цагдаагийн газарт хохирогчид ойртохыг хориглосон тушаал буулгах хүсэлт тавих юмуу, хуулийн байгууллагын хамгаалалтанд орох хүсэлтийг гаргаж болно.
- Хохирогч хохирлын нөхөн төлбөр авч чадаагүй бол хянан шийдвэрлэлттээр дамжуулан Улсын прокурорын ерөнхий газраас эмчилгээний зардал болон санхүүгийн туслалцаа авч болно. (Жич, солонгос улсад оршин суух эрхтэй байх, хохирогч нь гадаад иргэн бол гадаадын иргэний үнэмлэхтэй байх.)
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч нь мөрдөн байцаалт болон шүүх явц мөн хамгаалалтанд байх хугацаа зэрэг бүрэн дуустал оршин суух хугацааны сунгалт хийлгэж болно. (Жич, гэр бүлийн хүчирхийлэгч нөхөр нь солонгос иргэн байх.)
- Хүн амины хэрэг, бэртэл гэмтэл зэрэг амь биед халдсан гэмт хэрэг болон хулгай, залилан зэрэг эд хөрөнгийн хохирлын золиос, бэлгийн хүчирхийлэл зэрэг гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд, мөрдөн байцаалтийн явцад шаардлагатай туслалцааг хууль бусаар оршин суугч байсан ч ялгаагүй авах боломжтой бөгөөд хэргийг хариуцсан байцаагч нь цагаачлалын албанд хувийн мэдээллийг мэдээлэхгүй байж болно.

※ Дэлгэрэнгүй мэдээллийг Улсын прокурорын ерөнхий газрын хохирогчид туслах төвтэй(☎1577-2584) холбогдон мэдээлэл авах юмуу эрүүгийн хуулийн сайт (www.kics.go.kr) руу орж шалгаж болно.

※ Улсын прокурорын газартай утсаар ярих ба биечлэн уулзах тохиолдолд орчуулагч шаардлагатай бол, харъяа прокурорын газарт орчуулгын үйлчилгээ байгаа эсэх талаар лавлах буюу тухайн орны элчин сайдын яам болон олон соёлт гэр бүлд туслах төв(☎1577-1366)тэй холбогдон орчуулагчийн үйлчилгээ авч болох талаар лавлаарай.

<Дээрх мэдээлэлтэй танилцсан> 20 он сар өдөр Нэр (гарынүсэг)

<Мэдээлэл авах арга> аман мэдээлэл шуудан FAX шуудан Бусад Хариуцагч (гарынүсэг)